“Даатгагч болон даатгаын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралт (Е)

**Маягт СЗХ04008**

**Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт**

<table>
<tr><td>1</td><td>Мэдэгдэл огноо</td><td>Он</td><td>2021</td><td>Сар</td><td>06</td><td>Өдөр</td><td>08</td></tr>
<tr><td>2</td><td>Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр</td><td colspan="6">Монгол Даатгал ХК</td></tr>
<tr><td>3</td><td>Даатгалын бүтээгдэхүүний нэр</td><td colspan="6">Хүнд даацын тээврийн хэрэгслийн цогц даатгал</td></tr>
<tr><td>4</td><td>Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр</td><td colspan="6">Автотээврийн хэрэгслийн даатгал</td></tr>
<tr><td rowspan="2">5</td><td rowspan="2">Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр</td><td colspan="3">Шийдвэрийн нэр</td><td colspan="2">Огноо</td><td>Дугаар</td></tr>
<tr><td colspan="3">ТУЗ-ийн Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэн бүртгүүлэх болон Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн журмыг батлах тухай</td><td colspan="2">2021.06.07</td><td>21/17</td></tr>
<tr><td>6</td><td>Цахимаар борлуулах эсэх</td><td colspan="6">☐Тийм ☒Үгүй</td></tr>
<tr><td rowspan="2">7</td><td rowspan="2">Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч</td><td colspan="3">Овог</td><td colspan="3">Нэр</td></tr>
<tr><td colspan="3">Батзориг</td><td colspan="3">Даваасүрэн</td></tr>
<tr><td colspan="8">Мэдээллийн төрлийг сонгоно уу.</td></tr>
<tr><td>8</td><td colspan="7">☐Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах<br>☒Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх</td></tr>
<tr><td colspan="8">Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл</td></tr>
<tr><td rowspan="2">9</td><td>Даатгалын зүйл</td><td colspan="6">• Чиргэгч болон чиргүүлээс бүрдсэн, зөвшөөрөгдсөн зам дээр тодорхой маршрутын дагуу тээвэрлэлт хийх зориулалт бүхий хүнд даацын тээврийн хэрэгсэл;<br>• Даатгуулагч зохих нэмэлт хураамжийг төлсний үндсэн дээр дараах даатгалын зүйлийг нэмэлтээр даатгуулж болно.<br>  • Хүнд даацын тээврийн хэрэгслийг жолоодогч жолоочийн өмчлөгчийн өмнө хүлээх хариуцлага;<br>  • Хүнд даацын тээврийн хэрэгслийг жолоодогч жолоочийн гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн өмнө хүлээх хариуцлага;<br>  • Хүнд даацын тээврийн хэрэгслийг жолоодогч жолоочийн амь нас, хөдөлмөрийн чадвар бүрэн алдалт.</td></tr>
<tr><td>Даатгалын үндсэн эрсдэл</td><td colspan="6">Хүнд даацын тээврийн хэрэгсэл зориулалтын зогсоолд болон гражид байх үеийн эрсдэлүүд. Үүнд:<br>• Байгалийн бүх эрсдэлүүд;<br>• Сантехникээс үүдэлтэй эрсдэлүүд;<br>• Галын эрсдэлүүд;<br>• Хүнд даацын тээврийн хэрэгслийн агуулах байрны нуралт;<br>Зам тээврийн хөдөлгөөнд оролцож байх үеийн бүх эрсдэлүүд. Үүнд:<br>• Байгалийн бүх эрсдэлүүд;<br>• Галын эрсдэлүүд (гаднаас үүссэн гал, цахилгааны утаснаас үүдэлтэй гал);<br>• Цуваагаар явж байх үеийн бүх осол;<br>• Бусад тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх, шүргэлдэх;<br>• Түр зогсох, саатах үеийн эрсдэлүүд;<br>• Аливаа гадны зүйлээс үүдэлтэй хохирол;<br>Ачааг ачиж буулгаж байх үеийн эрсдэлүүд. Үүнд:<br>• Ачигч механизмаас үүдэлтэй хохирол;<br>• Ачааг буулгаж байх үеийн эрсдэл;</td></tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | Даатгалын нэмэлт эрсдэл | Даатгуулагч зохих нэмэлт хураамжийг төлсний үндсэн дээр дараах хамгаалалтыг нэмэлтээр авч болно. Үүнд:<br>• Хүнд даацын тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн алдаатай үйлдэл, хайхрамжгүй, санамсар болгоомжгүй байдлын улмаас өмчлөгчид хохирол учруулах;<br>• Хүнд даацын тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн алдаатай үйлдэл, хайхрамжгүй, санамсар болгоомжгүй байдлын улмаас гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учруулах;<br>• Хүнд даацын тээврийн хэрэгслийн жолооч ажил үүргээ гүйцэтгэж явах үед гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн алдах, нас барах; |
| | Даатгалын хураамжийн хувь, хэмжээ | Даатгалын хураамжийг тооцохдоо хүнд даацын тээврийн хэрэгслийн эрсдэлийн түвшин, ашигласан жилээс хамааруулан тогтоох ба цогц даатгалд хамаарах тус бүрийн үнэлгээнээс хамааран 0.8%-1.42% байна. |